



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 22 өдөр

Дугаар А/430

Мандалговь

Тусгай зөвшөөрлийн эрх
олгох, сунгах, хүчингүй болгох тухай

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3 дахь заалт, 7 дугаар зүйлийн 7.2, 9 дүгээр зүйлийн 9.1.2, 16 дугаар зүйлийн 16.2.5 дахь заалт, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.2, 6.3 дахь заалт, 7 дугаар зүйл, 14 дүгээр зүйлийн 14.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дундговь аймгийн Татварын хэлтэст бүртгэлтэй Дэлгэрцогт сумын “Зэст би эс ди” ХХК-ний хүнсний дэлгүүрийн архи, согтууруулах ундаа худалдан борлуулах тусгай зөвшөөрлийн эрхийг 2021 оны 11 дүгээр сарын 22-ны өдрөөс 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр хүртэлх хугацаагаар сунгасугай.

2. Сайнцагаан сумын “Зараагийн нүхэн” ХХК-ний хүнсний дэлгүүрт архи согтууруулах ундаа худалдан борлуулах, “Ортаг” ХХК-ний зоогийн газарт архи согтууруулах ундаагаар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг 2021 оны 11 дүгээр сарын 22-ны өдрөөс 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр хүртэлх хугацаагаар олгосугай.

3. Сайнцагаан сумын “Хишиг өгөөмөр” ХХК-ний Энхжин зоогийн газрын тусгай зөвшөөрлийн эрхийг 2021 оны 11 дүгээр сарын 22-ны өдрөөс хүчингүй болгосугай.

4. “Зараагийн нүхэн”, “Ортаг” ХХК-ний худалдаа үйлчилгээний газрын ажиллах цагийн хуваарийн хязгаарыг 08⁰⁰-24⁰⁰, Дэлгэрцогт сумын “Зэст би эс ди” ХХК-ний хүнсний дэлгүүрийн ажиллах цагийн хуваарийн хязгаарыг 09⁰⁰-21⁰⁰ цаг хүртэлх хугацаагаар тус тус баталсугай.

5. Гарсан шийдвэрийг холбогдох газруудад хуулийн хугацаанд мэдэгдэхийг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир), тухайн аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Б.Мөнхбат), Татварын хэлтэс (М.Туяацэцэг), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), холбогдох сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

431210625